



**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.9.3 дахь, 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монголын Хуульчдын холбооны “Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ

Монголын Хуульчдын холбооны
Зөвлөлийн 2025 оны 05 дугаар
сарын 02-ны өдрийн хурлын 05
дугаар тогтоолын ХАВСРАЛТ

9021110023 ГСТ7250

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилго

1.1. Энэ журмын зорилго Монголын Хуульчдын холбоо /цаашид “Хуульчдын холбоо” гэх/-ны төсөв, хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гишүүдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл. Журмын үйлчлэх хүрээ

2.1. Хуульчдын холбооны эд хөрөнгө, төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтны санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцаанд энэ журам үйлчилнэ.

2.2. Энэ журамд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал тэдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна:

- 2.2.1. Хуульчдын холбооны төсөв;
- 2.2.2. Хуульчдын холбооны хөрөнгийн зарцуулалт;
- 2.2.3. Хуульчдын холбооны хуримтлалын сан;
- 2.2.4. Хуульчдын холбооноос Салбаруудад хуваарилсан төсөв, хөрөнгө;
- 2.2.5. Хуульчдын холбооны гадаад болон дотоод зээл, хандив, тусламж, буцалтгүй тусламжийн орлого, тэдгээрийн зарцуулалт;
- 2.2.6. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээс олсон орлого, түүний зарцуулалт;
- 2.2.9. Бусад орлого, зарлага.

2.3. Хуульчдын холбооны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан гишүүдэд мэдээлэхээс аливаа хэлбэрээр зайлсхийхийг хориглоно.

3 дугаар зүйл. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын зарчим

3.1. Энэ журмыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 3.1.1. Хуульчдын холбооны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх;
- 3.1.2. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх;
- 3.1.3. Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;
- 3.1.4. Мэдээлэл ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх;
- 3.1.5. Мэдээлэл ашиглахад эрх тэгш боломжтой байх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4 дүгээр зүйл. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээлэл хүргэх хэлбэр

4.1. Хуульчдийн холбоо нь санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан гишүүдэд хүргэх бөгөөд цахим хуудас нь дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1. санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын бие даасан үндсэн цэстэй байх;

4.1.2. мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх;

4.1.3. тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх;

4.1.4. мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх.

4.2. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг дуу дүрсний бичлэгийн хэлбэрээр байршуулж болно.

4.3. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын цахим хуудсыг Тамгын газар эрхлэн хөтөлнө.

4.4. Энэ журмын 4.1, 4.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг шаардлага, агуулга, мэдээлэл тавих хэлбэрийг Тамгын газрын саналыг үндэслэн Зөвлөл тогтооно.

4.5. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын цахим хуудасны цэс нь энэ журмын 2.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.

5 дугаар зүйл. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээлэл

5.1. Тамгын газрын дарга нь дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

5.1.1. тухайн жилийн батлагдсан төсөв, хуримтлалын сангийн төлөвлөлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;

5.1.2. хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор;

5.1.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь аудит хийгдсэн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор;

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

6 дугаар зүйл. Мэдээлэх албан тушаалтан

6.1. Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг энэ журмын дагуу гишүүдэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

6.1.1. Батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэлийн тайланг санхүүгийн асуудал хариуцсан ажилтан, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ХЯНАЛТ

7 дугаар зүйл. Журмын хэрэгжилтэд тавих хяналт

7.1. Хуульчдын холбооны санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг Зөвлөл болон Хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

7.2. Салбарын санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдалд тавих дотоод хяналтыг Тамгын газрын дарга хэрэгжүүлнэ.

7.3. Хяналтын зөвлөл нь өөрийн санаачилгаар Хуульчдийн холбооны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж болно.

7.4. Энэ журмын хэрэгжилтийн явц, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийг зөрчил, дутагдалтай гэж үзсэн гишүүн шаардлагаа Тамгын газрын даргад гаргана. Хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг гишүүн Зөвлөл, эсхүл Хяналтын зөвлөлд гаргаж болно.

7.5. Зөвлөл, эсхүл Хяналтын зөвлөл нь гомдол, мэдээллийн дагуу тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тухайн гишүүнд бичгээр мэдэгдэж, энэ тухай нийт гишүүдэд мэдээлнэ.